



**МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 05 дүгээр сарын 25-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6.4, Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрдугаар зүйлийн 2.9, Үндэсний зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын уялдааг хангах, тогтоолын биелэлтийг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албанд үүрэг болгосугай.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажлуудыг Монгол улсын хөгжлийн бодлогын бичиг баримттай уялдуулан хуулийн хүрээнд санхүүжүүлж, дэмжин ажиллахыг Үндэсний зөвлөлийн гишүүд, нийслэл, аймаг орон нутгийн салбар зөвлөл, Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Үндэсний зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

5. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор холбогдох арга хэмжээний төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, тайланг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн ажлын албанд ирүүлж, ажиллахыг орон нутгийн салбар зөвлөлд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
БӨГӨӨД ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
БӨГӨӨД ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ОРЛОГЧ ДАРГА



Т.ОЮУН-ЭРДЭНЭ

С.БЯМБАЦОГТ

080000021